

МОНГОЛБАНКНААС ЗЭЭЛ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ АКТИВТАЙ ХОЛБООТОЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛД ӨӨРЧЛӨЛТ ОРСОНТОЙ ХОЛБООТОЙГООР ГАРЧ БУЙ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

1. Монголбанкнаас гарсан энэ удаагийн шийдвэрээр бүх банкууд өөрсдийн олгосон зээлийн хугацааг 12 сараар сунгах үүрэг хүлээсэн үү?

Үгүй. Банкууд зээлийн нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр бие даан шийдвэр гарган ажиллах боломжийг нээлттэй үлдээсэн. Өөрөөр хэлбэл, зээлдэгч зээлийн гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлээ төлөх боломжгүй болсон шалтгаанаар зээлийн эргэн төлөх нөхцөлийг өөрчилж, хугацаа сунгахад Монголбанкнаас гаргасан журмын дагуу банкууд уг зээлдэгчийн зээлийн чанарын ангиллыг бууруулах, улмаар Монголбанкны Зээлийн мэдээллийн санд мэдээлэх үүрэг хүлээсэн байдаг.

Харин энэ удаагийн шийдвэрээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж зээлийн хугацааг 12 хүртэл сараар сунгасан тохиолдолд зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх эсэхийг одоогоор мөрдөгдөж буй журмын хөнгөлөлт болон бусад шаардлагын хүрээнд бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад нээлттэй үлдээсэн.

2. Бүх зээлийн хугацааг 12 сараар сунгах боломжтой юу?

Үгүй. Зөвхөн Ковид-19 цар тахлын улмаас эргэн төлөлтөд хүндрэл учирсан хэрэглээний болон Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлүүдийн хувьд үлдэгдэл хугацааг 12 сараар сунгах боломжтой. Мөн Урт хугацаат дахин санхүүжилт (репо) болон Ажлын байрыг дэмжих гурван хувийн хүүтэй зээлийн хөтөлбөрт хамрагдсан зээл бол дахин хугацааг сунгахгүй.

3. Өмнө нь зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан зээлдэгчид хэрэглээний зээлийн хугацааг дахин сунгах боломжтой юу?

Тийм. Өмнө нь зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан эсэхээс үл хамаарч зээлийн үлдэгдэл хугацааг 12 хүртэлх сараар сунгах боломжтой.

4. Энэ удаагийн шийдвэр хэр хугацаанд үйлчлэх вэ?

Энэ удаагийн шийдвэр 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хэрэгжинэ.

5. Зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулж, хугацааг сунгах хүсэлтээ гаргахад иргэд, аж ахуйн нэгжүүд ямар материал бүрдүүлэх ёстой вэ?

Орлого тасалдаж, зээлийн эргэн төлөлтийг хийхэд хүндрэл учирсан зээлдэгчид банкинд хүсэлтээ гарган нөхцөлөө өөрчлөх боломжтой. Банкны зүгээс байгууллагын тодорхойлолт эсвэл дансны хуулга болон бусад холбогдох материалууд дээр үндэслэн орлого тасалдсаныг тогтоож ажиллана.

6. Зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоног гэж юу вэ?

Зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоног гэж зээлдэгч зээлийн гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийг зөрчиж зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлсэн хоногийг

хэлнэ. Банкууд хугацаа хэтрүүлсэн зээлийн мэдээг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд шилжүүлэх үүрэгтэй.

Энэ удаагийн Монголбанкнаас гарсан шийдвэрээр зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоногийг /2020 онд 90 хоног болгосон байгааг/ 2021 оны 8 дугаар сараас 75 хоног, 2021 оны 10 дугаар сараас 60 хоног, 2021 оны 12 дугаар сараас 45 хоног, 2022 оны 02 дугаар сараас 30 хоног, 2022 оны 4 дүгээр сараас 15 хоног болгож, хэвийн горимд аажмаар шилжүүлэхээр зохицуулсан.

7. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, ЗГ-аас тогтоосон хөл хорио урт хугацаанд буюу 75 хоногоос дээш хугацаанд үргэлжилж зээлдэгч 75 хоногоос урт хугацаагаар зээлээ төлөхгүй хэтрүүлбэл яах вэ?

Зээл, хувьсах нөхцөлтэй активыг хугацааны үзүүлэлтээр дүгнэж, ангилахдаа 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг дуустал зөвхөн Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тохиолдолд уг хугацаанд зээл, хүүгийн төлбөр төлөгдөөгүй хоногийг хасаж тооцохоор зохицуулалтыг тусгасан байгаа. Иймд хөл хорио тогтоосон хугацааг хугацаа хэтрүүлсэн хоногт тооцохгүй. Гэхдээ хэсэгчилсэн болон тусгайлан тогтоосон хөл хорионы хугацаа үүнд хамаарахгүй болохыг анхаарна уу.

8. Өмнө нь түр түдгэлзүүлсэн, хэрэглээний зээлд тавигдах өр, орлогын харьцаа болон эргэн төлөгдөх хугацааны шаардлага цаашид мөрдөгдөх үү?

Тийм. Монголбанкнаас хэрэглээний зээлд хамаарах өр, орлогын харьцааны дээд шаардлагыг хэрэглээний зээлийн хувьд 60 хувь, малчны зээлийн хувьд 70 хувь байхаар тогтоосон бол хэрэглээний зээлийн эргэн төлөгдөх хугацааг 30 сараар тогтоосон байдаг. 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө мөрдүүлж байсан хөнгөлөлттэй зохицуулалтын үйлчлэх хугацаа дууссантай холбоотойгоор дээрх шаардлагыг хэрэглээний зээлийн хувьд цаашид мөрдөж эхлэх юм.

Гэхдээ Монголбанкнаас тогтоосон аргачлалын дагуу уг шаардлагыг Иргэдийн цалин, тэтгэвэрийн зээл, кредит картын зээл, овердрафт эрхтэй харилцах данс, малчны зээл, автомашины зээл, автомашины лизинг болон эдгээртэй адилтгах зээлүүдэд мөрдүүлэх юм.

Харин эдгээрээс бусад буюу хадгаламж барьцаалсан зээл, ипотекийн зээл, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл, иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаанд зориулсан зээл, лизинг, иргэдийн жижиг дунд үйлдвэрлэлийн зориулалттай иргэнд олгосон зээлүүд дээрх шаардлагад хамаарахгүй.

9. Хэрэглээний зээл авсан зээлдэгчийн орлого буураагүй ч өрхийн гишүүн нь түр хугацаанд ажилгүй, орлогогүй болсон тохиолдолд энэ хөнгөлөлтөд хамрагдах боломжтой юу?

Боломжтой. Гэхдээ зээлдэгч нь нэгдүгээрт, ажилгүй эсвэл орлого тасалдсан иргэнийг өөрийн өрхийн гишүүн гэдгийг, хоёрдугаарт, тухайн өрхийн гишүүн нь Ковид-19 цар тахлын улмаас орлого тасалдсан гэдгийг нотлох шаардлагатай.

10. Зээлдэгч зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд заавал 12 сараар зээлийн хугацааг сунгах уу?

Үгүй. Зээлдэгч нь банктайгаа тохиролцож зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах боломжтой бөгөөд 12 сар эсвэл түүнээс бага хугацаагаар зээлийн үлдэгдэл хугацааг сунгаж болно.

11. Зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулахад өр, орлогын харьцаа нь 60 хувиас өндөр байгаа зээлүүдийн хувьд хугацаа сунгаж болох уу?

Болно. Гэхдээ өр, орлогын харьцаа болон эргэн төлөгдөх хугацааны шаардлага тавигдаж байгаа хэрэглээний зээлийн хувьд (Асуулт 8.-аас үзэх) уг шаардлагад нийцүүлэн хугацааг сунгах шаардлагатай болно.

Бусад зээлүүдийн хувьд банкны дотоод зээлийн бодлого, шаардлагад нийцүүлэн зээлийн үлдэгдэл хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар сунгах боломжтой.

12. Хэрэглээний зээлийн үлдэгдэл хугацааг 12 сараар сунгахад Монголбанкнаас тогтоосон хязгаарлалт байгаа юу ?

Байгаа. Зөвхөн Монголбанкнаас тогтоосон хугацаа (30 сар) болон өр, орлогын харьцааны (60 хувь) хязгаарлалтын хүрээнд боломжтой (Асуулт 8.-аас үзэх). Жишээлбэл, үлдэгдэл зээлийн хугацаа 18 сар, зээлдэгчийн өр, орлогын харьцаа 60 хувиас бага тохиолдолд банк болон зээлдэгчид тохиролцон зээлийн үлдэгдэл хугацааг 12 хүртэлх сараар сунгах боломжтой юм.

Харин үлдэгдэл зээлийн хугацаа 24 сар, зээлдэгчийн өр, орлогын харьцаа 60 хувиас бага тохиолдолд зээлийн нөхцөлийг зөвхөн 6 сараар сунгах боломжтой юм.

Зээлдэгчийн зээлийн хугацааг 12 хүртэл сараар сунгаснаар өр, орлогын харьцаа буурч улмаар зээлдэгчид учрах санхүүгийн дарамт буурна гэж үзэж байгаа.

13. Зээлийн үлдэгдэл хугацаагаа 12 сараар сунгахдаа Монголбанкнаас тогтоосон хугацаа (30 сар) болон өр, орлогын харьцааны (60 хувь) хязгаарлалтын хүрээнд зээлийн дүнгээ нэмэгдүүлэх замаар нэмж зээл авч болох уу?

Болохгүй. Энэ зохицуулалтын хүрээнд хэрэглээний зээлийг зөвхөн сунгах боломжийг нээж өгсөн байгаа.

14. Зээлдэгч 2 буюу түүнээс дээш зээлтэй тохиолдолд бүгдийг нь 12 сараар сунгах боломжтой юу?

Болно. Зээл тус бүр дээр сунгах боломжтой.

15. Хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулахад өр, орлогын харьцаа нь 60 хувиас өндөр байгаа зээлүүдийн хувьд хугацаа сунгаж болох уу?

Болохгүй. (Асуулт 8.-аас үзэх) Өмнөх хөнгөлөлттэй зохицуулалтын хүрээнд хэрэглээний зээлийн өндөр өр, орлогын харьцааг харгалзахгүйгээр авсан зээлүүдийн хувьд орлого буурах, дахин зээл авсан зэрэг шалтгаанаар өр, орлогын харьцаа нь 60 хувиас давах тохиолдол гарахыг үгүйсгэхгүй.